



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.06.05 № 124 ҮН-СН/2013/СТА-ЗГСНТ

Авлага, өглөгө баталгаажуулах  
тухай

Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Сангийн яам, төсөвт байгууллагуудтай авлага, өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулалгүй бүх төсөвт байгууллагын харилцах дансны оны эцсийн үлдэгдлийг Сангийн сайдын 2012 оны 295 дугаар тушаалаар улсын төсөвт шууд татан төвлөрүүлсэн нь өмнөх оноос бусад зардлын авлагыг 104.2 тэрбум төгрөгөөр, өглөгийг 176.4 тэрбум төгрөгөөр өсгөхөд хүргэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д: "Санхүү, төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т: "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д ".....алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг тус тус үндэслэн доорх албан шаардлагыг өгч байна.

1. Холбогдох байгууллагуудтай авлага, өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулж, 2013 оны 8 дугаар сарын 1-ний дотор авлага, өглөгийг барагдуулах арга хэмжээг авч ажиллах
2. Албан шаардлагаар өгсөн үүргийн биелэлтийг 2013 оны 10 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, Санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Ц.Ариунсанаа нарт даалгаж байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
АУДИТОР



И.ТУЯА